



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 9/25

Хархорин сум

Эзэмшил газрын хэлбэр
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.10.2 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Дэнж 1-6 тоотод байрлалтай иргэн Ч.Бямбацэрэнгийн худалдаа, нийтийн үйлчилгээний газар төв, цогцолборын зориулалтаар эзэмшиж байгаа 684м² газрыг тухайн зориулалтаар хэмжээг өөрчлөхгүйгээр талбайн байршлыг нь өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч "Ч.Бямбацэрэн"-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (Ч.Бямбацэрэн)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын газар эзэмшүүлэх тухай 2022 оны А/227 дугаар захирамж 0000144769 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

